

СЭЛЭНГЭ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Сэлэнгэ аймгийн Хушаат сумын төсвийн төвлөрүүлэн захирагчийн
2023 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд
хийсэн аудитын тайлан

Аудитын код: СЭА-2024/15-НА-СТА-ТТЗ

Цахим хуудас:
www.audit.mn
Хушаат сум
2024 он

Дарга, тэргүүлэх аудитор: Ч.Энхтуяа
Утас: 70363040 Цахим хаяг: Enkhtuyach@audit.gov.mn
Аудитын менежер: Б.Батмөнх
Утас: 70363036 Цахим хаяг: Batmunkhb@audit.gov.mn
Аудитор: Ц.Ундраа
Утас: 70362442 Цахим хаяг: undraats@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

Агуулга

1. Аудитын дүгнэлт.....	4-6
2. Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэл	7-12
3. Санхүүгийн тайлангийн тодруулга	13
3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа.....	13
3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин.....	13
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал.....	14
3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлт.....	15-22
4. Аудитын тайлан.....	23
4.1 Ерөнхий зүйл.....	23
4.2 Материаллаг байдал.....	23
4.3 Төрийн хэмнэлтийн хуулийн хэрэгжилт	23
4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал	23-25
4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	25
4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал.....	26
5. Аудитын илрүүлэлт	26-29
6. Аудитаар илэрсэн буруу илэрхийллийн нэгтгэл.....	30-31

Товчилсон үгийн жагсаалт

АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
АТӨЯХАТ	Авто тээвэр өөрөө явагч хэрэгслийн албан татвар
ЕБС	Ерөнхий боловсролын сургууль
ЗДНХ	Засаг даргын нөөц хөрөнгө
ЗДТГ	Засаг даргын Тамгын газар
ИТХ	Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал
МУЕА	Монгол Улсын Ерөнхий аудитор
ОНХО	Орон нутгийн хөрөнгө оруулалт
ОНХС	Орон нутгийн хөгжлийн сан
ТБОНӨХБАҮХА	Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ, худалдан авах тухай хууль
ТЕЗ	Төсвийн ерөнхийлөн захирагч
ТЗШ	Тусгай зориулалтын шилжүүлэг
ТТЗ	Төсвийн төвлөрүүлэн захирагч
ХХААХҮЯ	Хүнс хөдөө аж ахуй хөнгөн үйлдвэрийн яам
ХХОАТ	Хувь хүний орлогын албан татвар
ХХС	Хоршоо хөгжүүлэх сан



СЭЛЭНГЭ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

II баг, Цагаан эрэг, Сүхбаатар сум,
Сэлэнгэ аймаг, 43081
Утас/Факс: (976)-7036-3040
Цахим шуудан: Selenge@audit.gov.mn
Цахим хуудас: www.audit.mn

ХУШААТ СУМЫН ЗАСАГ ДАРГА
Н.ЗАХИРАХБААТАР ТАНАА

2024.03.26 № СЭА-2024/15-НА-СТА-ТТЗ
танай _____-ны № _____-т

Хязгаарлалттай дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.2-т заасны дагуу Хушаат сумын төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх нэгтгэсэн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Дүгнэлтийн үндэслэл хэсэгт дурдсан зөрчил нь материаллаг боловч өргөн тархаагүй гэж үзсэн бөгөөд санхүүгийн тайланд үзүүлэх үр нөлөөг эс тооцвол Сэлэнгэ аймгийн Хушаат сумын төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Санхүүгийн тайлангийн аудитаар илэрсэн зөрчлүүд нь бидний тогтоосон 14,480.6 мянган төгрөгийн материаллаг байдлын түвшнээс өндөр бөгөөд Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1, 13.7 дахь заалтууд болон Засгийн Газрын 2019 оны 05 дугаар тогтоолын 03 дугаар хавсралтаар баталсан "Төрийн албан хаагчид мөнгөн урамшуулал олгох журам"-ын 1 дүгээр зүйлийн 1.2.1 дэх заалтуудыг тус тус зөрчсөн байна.

Асуудлыг онцолсон хэсэг

Хушаат сумын төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2023 оны үйл ажиллагаанд зарцуулахаар 1,723,378.2 мянган төгрөг төлөвлөж, гүйцэтгэлээр 1,558,234.9 мянган

СЭА-2024/15-НА-СТА-ТТЗ

төгрөгийг зарцуулан, төсвийн гүйцэтгэл 90.4 хувьтай тайлагнагдсан бөгөөд батлагдсан төсвийг 165,143.3 мянган төгрөгөөр буюу 9.6 хувиар хэмнэсэн байна.

Аудитын гол асуудал

Хушаат сумын Засаг даргын 2022 оны 11 дүгээр сарын 25-ны өдрийн Б/36 дугаар захирамжаар сумын ЗДТГ-ын Санхүүгийн албаны дарга О.Цогбаярыг ЗДТГ-ын даргын албан тушаалыг түр орлон гүйцэтгэгчээр томилсон нь 2023 оны төсвийн жилд өөрчлөлт ороогүй байхад ЗДТГ-ын гаргасан бүх тушаал, шийдвэрт ЗДТГ-ын дарга гэж гарын үсэг зурж баталгаажуулсан байна.

Мөн сумын орон нутгийн төсвийн бүрдүүлэлт, зарцуулалтад хяналт тавьж, ажил гүйлгээг баталж, хэрэгжүүлэх чиг үүрэг бүхий Санхүүгийн албаны даргаар сумын ЗДТГ-ын төсвийн шууд захирагчийн чиг үүргийг давхар хашуулсан нь төсвийн хөрөнгийн зарцуулалтад тавих дотоод хяналтын үр нөлөөг сулруулсан байна.

Сумын ИТХ -ын бараа, үйлчилгээний бусад зардалд хүмүүнлэгийн тусламж, түр хамгаалах байрны зардлыг санхүүжүүлэх зорилгоор 10,000.0 мянган төгрөгийн төсөв баталж, байгалийн гамшигт өртсөн өрх, иргэдэд тусламж олгох, түлээ нүүрсний хөнгөлөлт олгох, түр хамгаалах байранд хөрөнгө худалдаж авах зэрэгт зарцуулсан байна.

Бусад асуудлын хэсэг

Сумын ИТХ нь Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилтийг “Хангалттай” гэж дүгнэсэн байна.

Аймгийн ЗДТГ-ын хяналт шалгалт, үнэлгээний дүнгээр тус сумын 2023 оны үйл ажиллагааг 91.0 хувиар үнэлж, аймгийн шилдэг сумын 4 дүгээрт шалгарсан байна.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.


Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ч.ЭНХТУЯА

2. АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН НЭГТГЭСЭН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн байдлын тайлан

/мянган төгрөгөөр/			
Код:	Тайлангийн үзүүлэлт	2022 оны 12-р сарын 31	2023 оны 12-р сарын 31
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	539,796.10	575,563.40
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	237,525.60	195,041.80
33	АВЛАГА	122,988.70	206,377.00
35	БАРАА МАТЕРИАЛ	179,281.80	174,144.60
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	1,088,419.80	1,231,862.40
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	1,088,419.80	1,231,862.40
39100	Газар	0	0
39200	Биет хөрөнгө	971,537.00	1,114,979.60
39300	Биет бус хөрөнгө	116,882.80	116,882.80
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	1,628,215.80	1,807,425.80
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	6,560.00	66,736.90
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	6,560.00	66,736.90
41300	Өглөг	6,560.00	66,736.90
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	1,621,655.80	1,740,688.90
51	Засгийн газрын хувь оролцоо	1,621,655.80	1,740,688.90
51100	Засгийн газрын оруулсан капитал	310,470.40	310,470.40
51200	Хуримтлагдсан үр дүн	1,150,629.60	1,269,662.70
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	160,555.80	160,555.80
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	1,628,215.80	1,807,425.80

2.2 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн үр дүнгийн тайлан

/мянган төгрөгөөр/			
Код:	Тайлангийн үзүүлэлт	2022 оны 12-р сарын 31	2023 оны 12-р сарын 31
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	1,694,863.00	1,809,769.80
11	ТАТВАРЫН ОРЛОГО	430,379.90	525,799.50
110	Орлогын албан татвар	156,280.30	231,720.00
1100	Хувь хүний орлогын албан татвар	156,280.30	248,947.40
1101	Хувь хүний орлогын албан татварын буцаан олголт	0	-17,227.40
113	Хөрөнгийн албан татвар	180,399.80	210,586.80
118	Бусад татвар, төлбөр, хураамж	93,699.80	83,492.70
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	342,132.40	321,457.00

120	Нийтлэг татварын бус орлого	342,132.40	321,457.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	922,350.70	962,513.20
II	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	988,629.00	1,448,029.60
21	УРСГАЛ ЗАРДАЛ	988,629.00	1,234,618.20
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	970,082.50	1,206,381.90
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	298,026.80	417,529.90
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	36,084.60	52,456.50
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	245,723.20	318,929.60
2104	Хангамж, бараа материалын зардал	51,677.70	51,475.20
2105	Норматив зардал	0	0
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	35,436.30	70,796.60
2107	Томилолт, зочны зардал	3,522.30	6,035.60
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	33,273.40	92,702.20
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	266,338.20	196,456.40
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	18,546.50	28,236.20
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	0	213,411.40
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)	706,233.90	361,740.20
V	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	2,823,890.40	242,707.20
VI	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(IV)-(V)	-2,117,656.50	119,033.10

2.3 Аудит хийсэн нэгтгэсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Код:	Тайлангийн үзүүлэлт	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн	Цөөнхийн хувь оролцоо	Нийт цэвэр хөрөнгө/өмч
1	2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	3,775,190.00	0	3,775,190.00
10	2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	1,621,655.80	0	1,621,655.80
3	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	3,739,312.40	0	3,739,312.40
2	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-35,877.70	0	-35,877.70
9	Тайлант үеийн үр дүн	-2,117,656.50	0	-2,117,656.50

11	2023 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	1,621,655.80	0	1,621,655.80
20	2023 оны 12-р сарын 31-наарх үлдэгдэл	1,740,688.90	0	1,740,688.90
13	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	1,621,655.80	0	1,621,655.80
19	Тайлант үеийн үр дүн	119,033.10	0	119,033.10

2.4 Аудит хийсэн нэгтгэсэн мөнгөн гүйлгээний тайлан

/мянган төгрөгөөр/

Код:	Тайлангийн үзүүлэлт	2022 оны 12-р сарын 31	2023 оны 12-р сарын 31
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)	1,397,490.50	1,530,789.90
11	ТАТВАРЫН ОРЛОГО	430,379.90	525,799.50
110	Орлогын албан татвар	156,280.30	231,720.00
1100	Хувь хүний орлогын албан татвар	156,280.30	248,947.40
1101	Хувь хүний орлогын албан татварын буцаан олголт	0	-17,227.40
113	Хөрөнгийн албан татвар	180,399.80	210,586.80
118	Бусад татвар, төлбөр, хураамж	93,699.80	83,492.70
1180	Бусад нийтлэг төлбөр, хураамж	6,729.20	9,477.40
1181	Газрын төлбөр	32,809.90	53,201.40
1182	Байгалийн нөөц ашигласны төлбөр	54,160.70	20,813.90
1183	Бусад татвар	0	0
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	42,609.90	40,627.10
120	Нийтлэг татварын бус орлого	42,609.90	40,627.10
121	Хөрөнгийн орлого	0	0
122	Тусламжийн орлого	0	0
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	924,500.70	964,363.20
II	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	786,313.80	995,310.10
21	УРСГАЛ ЗАРДАЛ	786,313.80	995,310.10
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	767,767.30	967,073.90
2101	Цалин хэлс болон нэмэгдэл урамшил	298,026.80	417,529.90
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	36,398.90	52,090.60
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	245,723.20	107,033.40
2104	Хангамж, бараа материалын зардал	47,785.20	51,306.00
2105	Норматив зардал	0	0

2106	Эд хогшил, урсгал засварын зардал	35,436.30	58,904.00
2107	Томилолт, зочны зардал	3,522.30	6,035.60
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	39,887.90	256,314.10
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	60,986.60	17,860.30
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	18,546.50	28,236.20
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)	611,176.70	535,479.80
V	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (V)	554,065.40	475,963.60
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	554,065.40	475,963.60
2200	Дотоод эх үүсвэрээр	554,065.40	475,963.60
2260	Гадаад эх үүсвэрээр	0	0
VI	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)	-554,065.40	-475,963.60
VII	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ДҮН	0	-102,000.00
23	ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨРИЙГ ХАССАН ЦЭВЭР ЗЭЭЛ	0	102,000.00
VIII	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VIII)=(III)+(VI)+(VII)	57,111.30	-42,483.80
101	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	180,414.20	237,525.60
20	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	237,525.60	195,041.80

2.5 Аудит хийсэн нэгтгэсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	/мянган төгрөгөөр/		
			Төсвийн гүйцэтгэлийн тайлан	Гүйцэтгэл зөрүү	Хувь
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	1,723,378.2	1,558,234.90	165,143.30	90
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,035,973.30	1,001,020.90	34,952.40	97
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,007,737.00	972,784.60	34,952.40	97
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	435,866.40	417,279.90	18,586.50	96
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	54,483.30	52,090.60	2,392.70	96
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	261,668.00	258,752.60	2,915.40	99

2104	Хангамж, бараа материалын зардал	50,069.50	50,067.30	2.20	100
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	91,546.60	91,546.10	0.50	100
2107	Томилолт, зочны зардал	6,035.60	6,035.60	0.00	100
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	81,852.50	81,702.20	150.30	100
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	26,215.10	15,310.30	10,904.80	58
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	28,236.30	28,236.20	0.10	100
2132	Бусад урсгал шилжүүлэг	28,236.30	28,236.20	0.10	100
	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	524,887.10	455,214.10	69,673.00	87
23	ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨРИЙГ ХАССАН ЦЭВЭР ЗЭЭЛ	162,517.80	102,000.00	60,517.80	63
III	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	1,723,378.20	1,512,491.00	210,887.20	88
32	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	1,494,427.10	1,487,979.40	6,447.70	100
35	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	228,951.10	24,511.60	204,439.50	11
4	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	0	176,779.50		
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	0	131,035.60		
6	ТӨСВИЙН БУСАД МЭДЭЭЛЛИЙН АНГИЛАЛ	38	36	2	
61	БАЙГУУЛЛАГЫН ТОО	2	2		
610001	Төсвийн байгууллага	2	2		
62	АЖИЛЛАГСДЫН ТОО	18	17	1	
620001	Удирдах ажилтан	5	4	1	
620002	Гүйцэтгэх ажилтан	9	9		
620003	Үйлчлэх ажилтан	4	4		
65	ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ	18	17	1	
650001	Төрийн захиргааны албан хаагч (ТЗ)	11	11		
650009	Төрийн үйлчилгээний бусад албан хаагч (ТҮ)	4	4		
650011	Улс төрийн албан хаагч (УТ)	3	2	1	
66	НИЙТ ТЭТГЭВЭРТ ГАРАГЧ	1	1		
660001	Төрийн албаны тухай хуулиар тэтгэвэрт гарагч	1	1		

2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

Код	Үзүүлэлт	/мянган төгрөгөөр/ ТЗ цэвэр дүн
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	21,168.70
21	УРСГАЛ ЗАРДАЛ	21,168.70
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	15,038.70
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	250.00
2104	Хангамж, бараа материалын зардал	1,238.70
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	11,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	2,550.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮДЭГ	6,130.00
2133	Олгосон санхүүжилт, шилжүүлэг	6,130.00
I	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	21,168.70
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	21,168.70
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	11,221.80
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	1,411.90
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	8,534.90

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Хушаат сумын ТТЗ-ийн үйл ажиллагааны эрхэм зорилгыг “Хамтдаа хэлэлцэж хөгжлийн гарцаа нээе. Хамтдаа шийдэж иргэнээ, өрх гэрээ, орон нутгаа хөгжүүлье” гэж тодорхойлсон байна.

Дээрх дэвшүүлсэн зорилт арга хэмжээний хүрээнд дор дурдсан үйл ажиллагааны стратегийн зорилтыг хэрэгжүүлэхээр тодорхойлсон байна. Үүнд:

- Төрийн ажил үйлчилгээний ил тод нээлттэй байдлыг хангах,
- Төрийн албан хаагчдын сахилга хариуцлагыг дээшлүүлэх,
- Төсөвт байгууллагуудын үйл ажиллагааг уялдуулж, иргэдийн оролцоог хангаж хамтран ажиллах,
- Төрийн бодлого, хууль тогтоомж, ИТХ-ын шийдвэрийг хэрэгжүүлэх, сурталчлах, биелэлтийг нь хангах ажлыг нутаг дэвсгэрийнхээ хэмжээнд зохион байгуулах үндсэн дээр хүн амын хүнсний аюулгүй байдлыг хангах, мал сүргийг өсгөн үржүүлэх, малын удмын сан, эрүүл мэндийг хамгаалах, мал эмнэлэг, үржлийн ажлыг зохион байгуулах, байгалийн гэнэтийн аюул, мал, амьтан, ургамлын халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээг бүрэн эрхийнхээ хүрээнд авч хэрэгжүүлэх,
- Харьяалах нутаг дэвсгэрийнхээ эдийн засаг, нийгмийн хөгжлийн стратегийн төлөвлөлт, хөтөлбөр, төсөл зохиох, зохицуулах, хяналт шинжилгээ хийх, үнэлж дүгнэх, бодлогын удирдамжаар хангах,
- Харьяалах нутаг дэвсгэрийнхээ болон засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж хоорондын, түүнчлэн бүс нутгийн чанартай үйлдвэрлэл, үйлчилгээ, нийгэм-соёлын зориулалттай барилга байгууламж барьж байгуулахад орон нутгийн болон хувийн хөрөнгө оруулалт хийх ажлыг дэмжиж, зохион байгуулах,
- Төрийн ажилтныг бэлтгэх, давтан сургах, мэргэшүүлэх, тэдний ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах ажлыг хууль тогтоомжийн хүрээнд зохион байгуулах,
- Нутаг дэвсгэрийн эдийн засаг, нийгмийн хөгжлийн хэтийн зорилт болон жилийн эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэлийн төсөл, гүйцэтгэлийн тайлан, орон нутгийн төсвийн болон түүнд нэмэлт, өөрчлөлт оруулах төсөл, төсвийн гүйцэтгэлийн тайланг батлуулахаар тухайн ИТХ-д оруулах, батлагдсан хөтөлбөр, төсөв, төслийг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах,
- Нутаг дэвсгэрийнхээ татварын орлогыг хууль тогтоомж, ИТХ-ын шийдвэрийн дагуу төвлөрүүлэх, шилжүүлэх ажлыг зохион байгуулах,
- Төрийн болон тухайн орон нутгийн өмчийн талаарх төрийн бодлого, хууль тогтоомж, ИТХ-ын шийдвэрийн биелэлтийг хангах ажлыг зохион байгуулах гэх мэт.

3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд дараах өөрчлөлтүүд орсон байна. Үүнд:

- *Монгол Улсын 2023 оны Төсвийн тухай хуулиар төсөв, санхүүжилттэй холбоотой,*
- *Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуульд 2023 оны 01 дүгээр сарын 06, 12 дугаар сарын 07-нд нэмэлт өөрчлөлт орсон,*
- *Төрийн албаны тухай хуульд 2023 оны 01 дүгээр сарын 06, 05 дугаар сарын 04, 06 дугаар сарын 16, 07 дугаар сарын 07, 11 дүгээр сарын 10, 12 дугаар сарын 07-нд нэмэлт өөрчлөлт орсон,*
- *Хөдөлмөрийн тухай хуульд 2023 оны 07 дугаар сарын 07-нд нэмэлт өөрчлөлт орсон,*
- *Төрийн хэмнэлтийн тухай хуульд 2023 оны 06 дугаар сарын 16, 07 дугаар сарын 07-нд нэмэлт өөрчлөлт орсон,*
- *Засгийн газрын 2023 оны 06 дугаар сарын 21-ний өдрийн 240 дүгээр тогтоолоор төрийн үйлчилгээний албан тушаалын зэрэглэл, албан тушаалын жагсаалтыг шинэчлэн тогтоосон,*
- *Засгийн газрын 2023 оны 06 дугаар сарын 21-ний өдрийн 241 дүгээр тогтоолоор төрийн албаны зарим албан тушаалын цалингийн хэмжээ, доод хэмжээг шинэчлэн тогтоосон гэх мэт.*

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилтийн үр нөлөө сул байна гэж үзлээ.

2023 онд тус ТТЗ-ийн төсөв, санхүүгийн үйл ажиллагаанд аймгийн Санхүүгийн хяналт, дотоод аудитын албанаас дотоод хяналт, шалгалт хийгдээгүй боловч ЗДТГ-ын СТСХ-ээс төсвийн гүйцэтгэлийн тайлан, мэдээ, шилэн дансны мэдээллээр дамжуулан дотоод хяналтыг хэрэгжүүлсэн байна.

Дотоод хяналт, шалгалтын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод хяналт, шалгалтын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Хушаат сумын ТТЗ нь 2023 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Хушаат сумын ТТЗ нь аймгийн Засаг даргын 2021 оны А/58 дугаар захирамжаар батлагдсан “Аймгийн ТЕЗ-ийн багцад хамаарах төсөвт

байгууллагуудад мөрдөх Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг"- ийг нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаандаа ашиглаж байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Хушаат сумын ТТЗ-ийн 2023 оны санхүүгийн нэгтгэсэн тайланг Сангийн сайдын 2015 оны 341 дүгээр тушаалаар баталсан “Төсвийн ерөнхийлөн захирагчийн болон Засгийн газрын санхүүгийн нэгтгэсэн тайлан, тодруулга бэлтгэх журам”-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогод өөрчлөлт ороогүй байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн нэгтгэсэн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 179,209.9 мянган төгрөгөөр буюу 11.0 хувиар өссөн байна.

Хүснэгт 1. Санхүүгийн нэгтгэсэн байдлын тайлангийн үзүүлэлт

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	/мянган төгрөгөөр/
			Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	237,525.6	195,041.8	42,483.8
Авлага	122,988.7	206,377.0	-83,388.3
Бараа материал	179,281.8	174,144.6	-5,137.2
Үндсэн хөрөнгө	1,088,419.8	1,231,862.4	143,442.6
Нийт хөрөнгө	1,628,215.9	1,807,425.8	179,209.9
Өр төлбөр	6,560.0	66,736.9	-60,176.9
Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/	1,621,655.9	1,740,688.9	119,033.0
Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн	1,628,215.9	1,807,425.8	179,209.9

Дээрх хүснэгтээс харахад өмнөх оны үзүүлэлтээс нөлөө бүхий өөрчлөлт гарсан мөнгөн хөрөнгө, авлага, бараа материал, үндсэн хөрөнгө, өр төлбөр, засгийн газрын хувь оролцоо данс байгаа бөгөөд өөрчлөлтийг тус бүрээр нь тайлбарлан харуулсан болно.

3.4.1 Мөнгөн хөрөнгө

Мөнгөн хөрөнгийн дансны эцсийн үлдэгдэл 195,041.8 мянган төгрөг болж, өмнөх оноос 42,483.8 мянган төгрөгөөр буурсан байна.

Хүснэгт 2. Мөнгөн хөрөнгийн үлдэгдэл

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	/мянган төгрөгөөр/
			Өсөлт (+), Бууралт (-)
Банканд байгаа бэлэн мөнгө	237,525.6	195,041.8	-42,483.8
Төгрөг	237,525.6	195,041.8	-42,483.8
Төрийн сангийн харилцах	237,525.6	195,041.8	-42,483.8
Арилжааны банк дахь харилцах			
Дүн	237,525.6	195,041.8	-42,483.8

Эх сурвалж: Хушаат сумын санхүүгийн нэгтгэсэн тайлан

Мөнгөн хөрөнгийн дансны үлдэгдэлд орон нутгийн ерөнхий орлогын үлдэгдэл 64,006.1 мянган төгрөг, ОНХС-ийн үлдэгдэл 101,980.6 мянган төгрөг, Хоршоог хөгжүүлэх сангийн үлдэгдэл 29,055.1 мянган төгрөг тус тус байршиж байна.

3.4.2 Авлага

Авлага дансны эцсийн үлдэгдэл 206,377.0 мянган төгрөг болж, өмнөх оноос 83,388.3 мянган төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт 3. Авлагын үлдэгдэл

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	/мянган төгрөгөөр/
			Өсөлт (+), Бууралт (-)
Ажиллагчтай холбогдсон авлага	365.9		-365.9
Татаас, санхүүжилтийн авлага			
Зээлийн хүүгийн авлага	7,480.8	13,656.2	6,175.4
Байгууллагаас авах авлага			
Хувь хүмүүсээс авах авлага	31,790.2	29,940.2	-1,850.0
Хувь хүмүүст олгосон зээл	83,351.8	162,780.6	79,428.8
Дүн	122,988.7	206,377.0	83,388.3

Эх сурвалж: Хушаат сумын санхүүгийн нэгтгэсэн тайлан

Авлагын үлдэгдэл 206,377.0 мянган төгрөг болж 83,388.3 мянган төгрөгөөр нэмэгдсэн нь хувь хүмүүсээс авах авлага 1,850.0 мянган төгрөгөөр, Хоршоог хөгжүүлэх сангаас хувь хүмүүст олгосон зээлийн эргэн төлөлтийн авлага 16,395.8 мянган төгрөгөөр буурч, 1 ААН, 6 иргэнд 101,634.1 мянган төгрөг зээлийг нэмж олгосонтой холбоотой байна.

Насжилт өндөртэй /3-аас дээш жил/ зээлийн авлагыг барагдуулахаар холбогдох шатны шүүхэд хандаж 13 иргэний нийт 104,742.9 мянган төгрөгийн нэхэмжлэлийг хүргүүлж, 7 иргэнийг ШШГГ-т шилжүүлсэн байна.

3.4.3 Бараа материал

Бараа материалын дансны эцсийн үлдэгдэл 174,144.6 мянган төгрөг болж, өмнөх оноос 5,137.2 мянган төгрөгөөр буурсан байна.

Хүснэгт 4 Бараа материалын үлдэгдэл

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	/мянган төгрөгөөр/
			Өсөлт (+), Бууралт (-)
Тусгай зориулалттай материал			
Эм боох материал			
Бэлэн бүтээгдэхүүн			
Бичиг хэргийн материал	457.0	287.8	-169.2
Аж ахуйн материал	736.0	640.0	-96.0
Сэлбэг хэрэгсэл			
Барилгын засварын материал			
Хүнсний материал			
Бусад хангамжийн материал	178,088.8	173,216.8	-4,872.0
Дүн	179,281.8	174,144.6	-5,137.2

Эх сурвалж: Хушаат сумын санхүүгийн нэгтгэсэн тайлан

ТТЗ-ийн бараа материалын дансны үлдэгдэл өмнөх оныхоос 5,137.2 мянган төгрөгөөр буурч 174,144.6 мянган төгрөг болсон нь тайлант онд төсвийн хөрөнгөөр 385,552.2 мянган төгрөгийн материал худалдан авсан, 30,591.7 мянган төгрөгийн бараа материалыг шилжүүлэн авсан, 172,873.4 мянган төгрөгийн бараа материалыг зарцуулсан, ОНХС-аар хийгдсэн ажлуудын 248,407.7 мянган төгрөгийн бараа материалыг ашиглагч байгууллагуудад шилжүүлсэнтэй холбоотой байна.

3.4.4 Үндсэн хөрөнгө

Үндсэн хөрөнгийн дансны эцсийн үлдэгдэл цэвэр дүнгээр 1,231,862.4 мянган төгрөг болж, өмнөх оноос 143,442.7 мянган төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт 5 Үндсэн хөрөнгийн үлдэгдэл

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Барилга, байгууламж, орон сууц	457,897.10	500,868.90	42,971.80
Авто-тээврийн хэрэгсэл	42,607.10	76,766.20	34,159.10
Машин тоног төхөөрөмж(компьютер)	89,618.20	152,194.90	62,576.70
Тавилга, аж ахуйн эд хогшил	15,009.40	10,857.80	-4,151.60
Зам, гүрийн байгууламж	24,790.30	58,961.60	34,171.30
Бусад үндсэн хөрөнгө	171,490.70	126,106.20	-45,384.50
Дуусаагүй барилга, байгууламж	100,124.00	119,224.00	19,100.00
Ном	70,000.00	70,000.00	0.00
Бусад биет бус хөрөнгө	116,882.90	116,882.90	0.00
НИЙТ ДҮН	1,088,419.70	1,231,862.40	143,442.70

Хушаат сумын санхүүгийн нэгтгэсэн тайлан

Үндсэн хөрөнгийн дансны үлдэгдэл 1,231,862.4 мянган төгрөг болж өмнөх оноос 143,442.7 мянган төгрөгөөр өссөн нь төсвийн хөрөнгөөр машин тоног төхөөрөмж, тавилга 20,749.5 мянган төгрөгөөр худалдан авсан, үнэ төлбөргүйгээр 266,634.0 мянган төгрөгийн хөрөнгө шилжүүлэн авч, 13,628.3 мянган төгрөгийн хөрөнгийг акталж, тайлант хугацаанд 130,312.5 мянган төгрөгийн элэгдэл тооцсонтой холбоотой байна.

3.4.5 Өр төлбөр

Нийт өр төлбөрийн дансны эцсийн үлдэгдэл 66,736.9 мянган төгрөг болж, өмнөх оноос 59,946.2 мянган төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт 6. Нийт өр төлбөрийн үлдэгдэл

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Байгууллагад төлөх өглөг	6,790.7	66,736.9	59,946.2
Дүн	6,790.7	66,736.9	59,946.2

Эх сурвалж: Хушаат сумын санхүүгийн нэгтгэсэн тайлан

Өр төлбөрийн дансны үлдэгдэл 66,736.9 мянган төгрөг байгаа нь сум хөгжүүлэх сангийн / ХХС / 2012 оны 4,960.0 мянган төгрөгийн өглөг, Эрчим хүчний зохицуулах зөвлөлөөс түлш халаалтын үнийг нэмснээс өмнөх онуудын үнийн СЭА-2024/15-НА-СТА-ТТЗ

зөрүүгээр төсвийн байгууллагуудад 61,776.9 мянган төгрөгийн өр үүсгэсэнтэй холбоотой байна.

3.4.6 Засгийн газрын хувь оролцоо

Засгийн газрын хувь оролцоо дансны эцсийн үлдэгдэл 1,740,688.9 мянган төгрөг болж, өмнөх оноос 119,033.1 мянган төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт 7. Засгийн газрын хувь оролцоо

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	/ мянган төгрөгөөр /	
		Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	310,470.4	310,470.4	
Өмнөх үеийн үр дүн	1,150,629.60	1,269,662.7	119,033.1
Тайлант үеийн үр дүн		119,033.1	
Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	160,555.8	160,555.8	
Дүн	1,621,655.8	1,740,688.9	119,033.1

Эх сурвалж: Хушаат сумын санхүүгийн нэгтгэсэн тайлан

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 119,033.1 мянган төгрөгөөр өссөн нь тайлант үеийн үр дүн өссөнөөс шалтгаалсан байна.

3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

Орон нутгийн төсвийн орлогын бүрдүүлэлт

Хушаат сумын ИТХ-ын “2023 оны тодотгосон төсвийг батлах тухай” 2023 оны 08 дугаар сарын 09-ний өдрийн 43 дугаар тогтоолоор татварын орлогыг 448,757.5 мянган төгрөгөөр, татварын бус орлогыг 11,000.0 мянган төгрөгөөр, нийт орон нутгийн орлогыг 459,757.5 мянган төгрөгөөр баталснаас гүйцэтгэлээр 541,914.9 мянган төгрөгийн орлого төвлөрүүлж, төлөвлөгөөг 69,374.8 мянган төгрөгөөр буюу 117.9 хувиар биелүүлсэн байна.

8. Төвлөрүүлэх орлого

Орлогын төрөл	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	/мянган төгрөг/	
			Зөрүү	Хувь
Татварын орлого	459,757.50	541,914.90	69,384.80	117.9
Үйл ажиллагааны орлого	16,000.00	40,054.40	24,054.40	250.0
Цалин хөлс, шагнал, урамшуулал болон тэдгээртэй адилтгах орлого	119,000.00	192,897.80	73,897.80	162.0
Хөрөнгийн орлого	13,000.00	13,024.30	24.30	100.0
Хөрөнгө борлуулсны орлого	3,000.00	2,970.90	-29.10	99.0
Үл хөдлөх эд хөрөнгийн албан татвар	8,800.00	6,886.90	-1,913.10	78.2

Бууны албан татвар	1,100.00	1,170.00	70.00	106.3
Малд ногдуулах албан татвар	240,000.00	202,529.90	-37,470.10	84.3
Улсын тэмдэгтийн хураамж	3,000.00	4,458.40	1,458.40	148.6
Түгээмэл тархацтай ашигт малтмал ашигласны төлбөр	150.00	151.00	1.00	100.6
Хог хаягдлын үйлчилгээний хураамж	6,600.00	4,867.90	-1,732.10	73.7
Газрын төлбөр	25,808.00	36,496.10	10,688.10	141.4
Дуудлага худалдаа	23,745.20	16,705.40	-7,039.80	70.3
Ойн нөөц ашигласны төлбөр	12,238.30	10,926.10	-1,312.20	89.2
Ан амьтны нөөц ашигласны төлбөр	1,316.00	1,635.00	319.00	124.2
Байгалийн ургамлын нөөц ашигласны төлбөр	5,000.00	8,252.80	3,252.80	165.0
Татварын бус орлого	11,000.00	16,115.40	5,115.40	146.5
Торгуулийн орлого	1,000.00	5,101.10	4,101.10	510.1
Бусад орлого	10,000.00	11,014.30	1,014.30	110.1
Хувь хүний орлогын албан татварын буцаан олголт	-30,000.00	-17,227.40		57.4
Нийт орлогын дүн	459,757.50	541,914.90	82,157.40	117.8

Эх сурвалж: Хушаат сумын ТТЗ-ийн 2023 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Тайлант онд ХХОАТ-ын орлого, үйл ажиллагааны орлого, улсын тэмдэгтийн хураамж, газрын төлбөр, байгалийн ургамал ашигласны төлбөр, бусад орлого тус тус давж биелсэн байна.

Малын тоо толгойн албан татвар, хог хаягдлын үйлчилгээний хураамж, хүү, торгуулийн орлого тус тус тасарсан байна.

Төсвийн орлогод нөлөөлөхүйц хэмжээний давсан болон тасарсан орлогуудын шалтгааныг тодруулбал:

Давж биелсэн орлогууд:

- **ХХОАТ-ын орлого:** Засгийн газрын 2023 оны 240, 241 дүгээр тогтоолуудаар төрийн албан хаагчийн цалингийн доод хэмжээг шинэчлэн тогтоосонтой холбоотойгоор цалин хөлс, шагнал, урамшуулал болон түүнтэй адилтгах хөдөлмөр эрхлэлтийн орлогоос суутган тооцох татварын орлого нэмэгдэж, 73,897.8 мянган төгрөгөөр,
- **Газрын төлбөр:** Тайлант онд газар эзэмших болон ашиглах бүртгэл шинэчлэн хийж, иргэд урьд онуудын нэхэмжилсэн төлбөрөө барагдуулснаас,
- **Байгалийн ургамал ашигласны төлбөр:** Бэлчээр болон хадлан сайн ургаж иргэд төлбөр хураамжаа барагдуулснаас тус тус орлогууд давж биелсэн байна.

Тасарсан орлогууд:

- **Малын тоо толгойн албан татвар:** 2022 онд малын хөлийн татварыг дутуу төлөвлөөгүй гэх үндэслэлээр 2023 онд өмнөх оны төлөвлөгөөг давхар төлөвлөснөөс шалтгаалан орлого тасарсан байна.
- **Хог хаягдлын үйлчилгээний хураамж:** Өрхүүд хог хаягдлын төлбөрөө гүйцэд төлөөгүйгээс шалтгаалсан байна.
- **Хүү, торгуулийн орлого:** Орлогыг тооцоо судалгаа муутай төлөвлөснөөс шалтгаалан тасарсан байна.

3.5.1 Төсвийн төлөвлөлт

Тайлант онд сумын төсөвт 2 удаа тодотгол хийсэн байна. Үүнд:

Сумын ИТХ-ын 2023 оны 1 дугаар сарын 25-ны өдрийн төсөв батлах тухай 36 дугаар тогтоолоор:

- Татварын болон татварын бус орлогыг 394,979.9 мянган төгрөг,
- Аймгаас суманд олгох санхүүгийн дэмжлэг 648,966.7 мянган төгрөг,
- Урьд оны үлдэгдлээс 55,218.2 мянган төгрөг,
- Орон нутгийн хөгжлийн сангийн эхний үлдэгдэл 148.2 мянган төгрөг,
- Аймгийн ОНХС-аас олгох шилжүүлгийг 200,835.6 мянган төгрөг,
- ОНХС-д орон нутгийн хөгжлийн сангийн гүйцэтгэлийн урамшууллаас олгох санхүүжилт 34,570.9 мянган төгрөг,
- ОНХС-д төвлөрүүлэх малын тоо толгойн албан татвар 69,777.6 мянган төгрөг,
- Хоршоо хөгжүүлэх сан 173,732.9 мянган төгрөг зэрэг нийт орлого, зарлагыг тус бүр 1,578,230.0 мянган төгрөгөөр баталсан байна.

Сумын ИТХ-ын 2023 оны 08 дүгээр сарын 09-ний өдрийн тодотгосон төсөв батлах тухай 43 дугаар тогтоолоор:

- Малын тоо толгойн албан татварын өмнөх онд төлөвлөөгүй 64,777.6 мянган төгрөгийг нэмж тодотгон нийт татварын болон татварын бус орлогыг 459,757.5 мянган төгрөг,
- Аймгаас суманд олгох санхүүгийн дэмжлэг 749,782.5 мянган төгрөг,
- Урьд оны үлдэгдлээс 55,218.2 мянган төгрөг,
- Орон нутгийн хөгжлийн сангийн эхний үлдэгдэл 148.2 мянган төгрөг,
- Аймгийн ОНХС-аас олгох шилжүүлгийг 250,168.0 мянган төгрөг,
- ОНХС-д орон нутгийн хөгжлийн сангийн гүйцэтгэлийн урамшууллаас олгох санхүүжилт 34,570.9 мянган төгрөг,
- Сумын хоршоо хөгжүүлэх сан 173,732.9 мянган төгрөг зэрэг нийт орлого зарлагыг тус бүр 1,723,378.2 мянган төгрөгөөр баталсан байна.

3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд төсвийн төвлөрүүлэн захирагчийн хэрэгжүүлэх 12 хөтөлбөрийн 22 арга хэмжээг санхүүжүүлэхээр 1,723,378.2 мянган төгрөгийн төсөв батлагдсанаас 1,024,758.2 мянган төгрөгийг урсгал зардалд, 524,887.1 мянган төгрөгийг хөрөнгийн

зардалд, ХХС-ийн зээлд 173,732.9 мянган төгрөгийг зарцуулахаар төлөвлөсөн байна.

Хүснэгт 9. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэлийг байгууллага тус бүрээр харуулбал:

<i>Имянган төгрөгөөр/</i>					
№	Байгууллагын нэр	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Биелэлт
1	Иргэдийн төлөөлөгчдийн хурал	101,856.20	91,584.80	10,271.40	89.90%
2	Засаг даргын тамгын газар	676,714.20	665,853.30	10,860.90	98.40%
3	Орон нутгийн хөгжлийн сан	524,887.10	455,214.00	37,618.30	92.80%
4	Хоршоо хөгжүүлэх сан	173,732.90	102,310.30	149,221.30	14.10%
5	ЕБС	136,750.60	136,382.00	368.6	99.70%
6	Эрүүл мэндийн төв	33,286.80	32,728.10	558.7	98.30%
7	Цэцэрлэг	48,048.00	46,932.50	1,115.50	97.70%
8	Соёлын төв	28,102.40	27,229.90	872.5	96.90%
	Нийт дүн	1,723,378.20	1,558,234.90	210,887.20	87.80%

сурвалж: Хушаат сумын ТТЗ-ийн 2023 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Гүйцэтгэлээр аймгийн төсвөөс олгох санхүүгийн дэмжлэгээс 661,325.5 мянган төгрөг, орон нутгийн орлогоос 541,914.9 мянган төгрөг, өөрийн орлогоос 24,511.7 мянган төгрөг, ОНХС-аас 284,738.9 мянган төгрөг, өмнөх оны үлдэгдлээс 176,779.5 мянган төгрөг зэрэг нийт 1,689,270.5 мянган төгрөгийн эх үүсвэрийг бүрдүүлж 1,558,234.9 мянган төгрөгийг зарцуулсан байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 1,558,234.9 мянган төгрөг буюу 92.2 хувьтай байгаа нь урсгал зардлыг 34,952.4 мянган төгрөгөөр, хөрөнгийн зардлыг 96,083.2 мянган төгрөгөөр тус тус хэмнэснээс шалтгаалсан байна.

Урсгал зардлын гүйцэтгэлийг төлөвлөгөөтэй харьцуулбал цалин хөлс, нэмэгдэл урамшуулал, ажил олгогчийн НДШ-ийн зардал нийт 20,979.2 мянган төгрөгөөр, байр ашиглалттай холбоотой тогтмол зардал 2,915.4 мянган төгрөгөөр, хангамж бараа материалын зардал 2.2 мянган төгрөгөөр, эд хогшил, урсгал засварын зардал 0.5 мянган төгрөгөөр, бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний төлбөр хураамж 150.3 мянган төгрөгөөр, урсгал шилжүүлэг 0.10 мянган төгрөг, бараа үйлчилгээний бусад зардал 10,904.8 мянган төгрөгөөр зэрэг нийт 34,952.4 төгрөгөөр хэмнэгдсэн байна.

Тайлант онд сумын ОНХС-ийн хөрөнгөөр хийгдэх нийт 21 төсөл, арга хэмжээнд 557,194.6 мянган төгрөгийн санхүүжилт батлагдсанаас гүйцэтгэлээр 455,214.0 мянган төгрөгийн санхүүжилт олгож, 101,980.6 мянган төгрөгийг орон нутгийн төсөвт төвлөрүүлсэн байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

5.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Аймгийн ЗДНХ-өөс 11,221.9 мянган төгрөг, аймгийн Статистикийн хэлтсээс 1,411.9 мянган төгрөг, үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого 8,534.9 мянган төгрөг зэрэг нийт 21,168.7 мянган төгрөгийн орлогыг бүрдүүлжээ.

Үүнээс цалин хөлс болон нэмэгдэл урамшуулал 250.0 мянган төгрөг, хангамж, бараа материалын зардал 1,238.7 мянган төгрөг, бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний төлбөрт 11,000.0 мянган төгрөг, бараа үйлчилгээний бусад зардалд 2,550.0 мянган төгрөг зэрэг нийт 15,038.7 мянган төгрөгийг зарцуулан, 6,130.0 мянган төгрөгийг төсөвт татан төвлөрүүлсэн байна.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

3.5.4 Худалдан авах ажиллагааны гүйцэтгэл

Тайлант онд худалдан авах ажиллагааны урилгыг ТБОНӨХБАҮХАТ хуульд заасны дагуу tender.gov.mn-д цахим сайтад бүрэн байршуулж, зохион байгуулсан байна. Үүнд:

Хөрөнгө оруулалтын ажлын эх үүсвэр	Төлөвлөсөн төсөл, арга хэмжээ		Үүнээс					
			ШХА		Харьцуулалтын арга		НТШ	
	Тоо	дүн	тоо	дүн	тоо	дүн	тоо	дүн
Сумын ОНХС	21	524,878.10	16	227,779.00	4	227,435.00		

: Хушаат сумын ТТЗ-ийн ХА ажиллагааны төлөвлөгөө, тайлан

4. АУДИТЫН ТАЙЛАН

4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана” гэж заасны дагуу Хушаат сумын ТТЗ-ийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Мөн анхан шатны баримтыг бүрэн бүрдүүлсний үндсэн дээр ажил гүйлгээг гүйцэтгэх, үндсэн хөрөнгийн дансанд бүртгэлтэй ашиглалтын хугацаа дуусаж, элэгдлээрээ анхны өртгөө бүрэн нөхсөн боловч ашиглагдаж байгаа хөрөнгийг бодит үнэ цэнээр нь үнэлж бүртгэх зэрэг зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор Ц.Ундраа гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер Б.Батмөнх, дарга, тэргүүлэх аудитор Ч.Энхтуяа нар тус тус хэрэгжүүлсэн.

Хушаат сумын ТТЗ нь 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газарт 2024 оны 03 дугаар сарын 03-ны өдрийн 1/18 дүгээр албан бичгээр ирүүлсэн байна.

4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2022 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт орлогыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг дунд гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2022 оны санхүүгийн үр дүнгийн нэгтгэсэн тайлангийн нийт зардал 988,629.00 мянган төгрөгөөс 1.0 хувиар буюу 9.886.3 мянган төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагатай гэж үзсэн.

Гүйцэтгэлийн материаллаг байдлыг 2023 оны санхүүгийн үр дүнгийн нэгтгэсэн тайлангийн нийт зардал 1,448,029.6 мянган төгрөгөөс 1.0 хувиар буюу 14,480.6 мянган төгрөгөөр тооцов.

4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Тус сум нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хүрээнд дараах арга хэмжээнүүдийг хэрэгжүүлсэн байна. Үүнд:

- Бичгийн цаас, принтерийн хорны зардлыг хэмнэх зорилгоор бичиг хэрэг, албан хэрэг хөтлөлтөд дотоод сүлжээг ашигласан,

- Автомашиныудад цэнхэр дэвсгэр бүхий дугаар авсан,
- Ээлжийн амралтаараа дотоодын амралт, сувилал, төрсөн нутагтаа амрах тохиолдолд очих, ирэх замын зардлыг олгоогүй,
- Шаардлагагүй бараа материалыг их хэмжээгээр авч нөөцлөлгүй ажилласан байна.

4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

д/д	Байгууллагын нэр	Мэдээлбэл зохих	Мэдээлсэн	Хугацаа хоцроосон	Мэдээлээгүй
1	Төсвийн төвлөрүүлэн захирагч	145	126	19	
2	Иргэдийн Төлөөлөгчдийн хурал	171	151	20	
3	Засаг даргын Тамгын газар	171	158	13	
	Нийт дүн	487	435	52	

Эх сурвалж: www.shilendans.gov.mn

Тайланг хугацаанд төсвийн төвлөрүүлэн захирагчийн дүнгээр нийт 487 мэдээллийг шилэн дансанд байршуулахаас 435 мэдээллийг хугацаанд нь байршуулж, 52 мэдээллийг хугацаа хоцроосон байна.

Энэ нь нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь Шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцээгүй байна гэж дүгнэлээ.

Шийдвэрлэсэн нь: Өмнөх аудитаар өгсөн албан шаардлагыг хэрэгжүүлэлгүйгээр тайлант онд зөрчлийг давтан гаргасан тул Төрийн аудитын тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.1 дэх заалтын дагуу холбогдох төсвийн захирагчдын нягтлан бодогчдод сахилгын шийтгэл ногдуулах албан шаардлага хүргүүлэв.

4.4.2 Худалдан авах ажиллагаа

ЗДТГ нь тайлант жилийн худалдан авах ажиллагааны төлөвлөгөө боловсруулан, батлуулж, тайлагнасан боловч шууд худалдан авах босго үнээс давсан 27,232.2 мянган төгрөгийн шатахууны худалдан авах ажиллагааг цахимаар, нийтэд нээлттэй, ил тод зарлаж, гүйцэтгэгчийг шалгаруулалгүйгээр НИК ХХК-иас худалдан авсан байна.

Энэ нь ТБОНӨХБАУХА тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.4 дэх “Тендер шалгаруулалтын журмыг сонгохдоо тухайн бараа, ажил, үйлчилгээний нийт төсөвт өртгийг үндэслэл болгоно.”, Засгийн газрын 2021 оны 124 дүгээр тогтоолын 1 дүгээр хавсралт “Шууд худалдан авч болох төсөвт өртгийн дээд хязгаар бараа -20.0 сая төгрөг ажил 20.0 сая төгрөг” гэсэн заалтуудыг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: ТБОНӨХБАУХА тухай хуулийн хэрэгжүүлэн ажиллах зөвлөмж хүргүүлэв.

4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

4.5.1 Завсрын аудитын талаар

Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, тэргүүлэх аудиторын 2023 оны 10 дугаар сарын 26-ны өдрийн 122 дугаар “Санхүүгийн тайланд аудит хийх тухай” албан бичгийг хүргүүлсэн бөгөөд тус байгууллагын 2023 оны 3 дугаар улирлын санхүүгийн тайланд хийсэн завсрын үеийн санхүүгийн тайлангийн аудитаар алдаа, зөрчил илрээгүй байна.

4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх аудитаар өгсөн албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилтийг холбогдох баримтын хүрээнд тулган шалгахад дунджаар 71.4 хувийн гүйцэтгэлтэй байна.

Хүснэгт 12. Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

Үзүүлэлт	Өмнөх аудитаар		/мянган төгрөгөөр/ Биелэлт		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Акт	-	-	-	-	-
Албан шаардлага	5	13,080.8	4	9,197.6	80.0
Зөвлөмж	2	19,384.4	1	-	50.0
Нийт дүн	7	33,065.2	5	9,197.6	71.4

Өмнөх аудитаар өгсөн 5 албан шаардлагаас 4-ийг хэрэгжүүлж, төсвийг зориулалт бусаар зарцуулсан зөрчлийг арилгах 1 албан шаардлагыг хэрэгжүүлдээгүй ЗДТГ-ын даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч, Санхүүгийн албаны дарга О. Цогбаярт сахилгын шийтгэл ногдуулах албан шаардлага хүргүүлэхээр, анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг гүйцэтгэж бүртгэл тайланд СЭА-2024/15-НА-СТА-ТТЗ

тусгасан 1 зөвлөмжийг хэрэгжүүлэлгүйгээр зөрчлийг давтан гаргасан тул албан шаардлага хүргүүлэхээр тус тус шийдвэрлэв.

4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ:

Залруулсан алдаа:

Аудитаар нягтлан бодох бүртгэл хөтлөлттэй холбоотой 7,516.5 мянган төгрөгийн алдааг залруулав. Үүнд:

ЗДТГ:

- 2022 онд худалдаж авсан 6,612.0 мянган төгрөгийн өртөг бүхий нөтбүүк, хүлэмжийг үндсэн хөрөнгийн дансанд орлого аваагүй,
- 904.5 мянган төгрөгийн элэгдлээрээ анхны өртгөө нөхөж дуусаагүй үндсэн хөрөнгийг актлахдаа үлдэх өртгийг гарзын дансанд бус бараа материал актлах дансанд бүртгэсэн.

Илрүүлсэн зөрчил:

Аудитаар нийт 61,568.8 мянган төгрөгийн зөрчил¹ илэрснээс 4,208.9 мянган төгрөгийн төлбөрийн акт, 47,648.4 мянган төгрөгийн албан шаардлага, цаашид алдаа зөрчлийг давтан гаргахгүй байх 9,711.5 мянган төгрөгийн зөвлөмж хүргүүлэв.

5.1 Төлбөрийн акт

1. Холбогдох албан тушаалтны шийдвэргүйгээр буюу анхан шатны баримтын бүрдэлгүйгээр ИТХ-ын дарга Ч.Гантөгст 1,577.8 мянган төгрөгийн, Засаг дарга Н.Захирахбаатарт 1,711.1 мянган зэрэг нийт 3,288.9 мянган төгрөгийн улирлын үр дүнгийн урамшуулал олгосон байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.7 дахь " Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно", Засгийн газрын 2019 оны 05 дугаар тогтоолын 03 дугаар хавсралтаар баталсан "Төрийн албан хаагчид мөнгөн урамшуулал олгох журам"-ын 1 дүгээр зүйлийн 1.2 дэх "Төрийн албан хаагчийн ажлын гүйцэтгэлийн үнэлгээ, улирлын ажлын үр дүнг үндэслэн төрийн албан хаагчид дараах эрх бүхий албан тушаалтан мөнгөн урамшуулал олгоно." 1.2.1: "Төсвийн ерөнхийлөн захирагч нь харьяа байгууллагын гүйцэтгэлийн үнэлгээ, ажлын үр дүнг үндэслэн холбогдох гүйцэтгэлийн үнэлгээний журамд тодорхойлсон мөнгөн урамшуулал авах нөхцөлийг хангасан төсвийн төвлөрүүлэн захирагч болон төсвийн шууд захирагчид" гэсэн заалтуудыг тус тус зөрчсөн байна.

¹ Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.
СЭА-2024/15-НА-СТА-ТТЗ

Шийдвэрлэсэн нь: Улирлын ажлын үр дүнг үнэлсэн холбогдох албан тушаалтны шийдвэргүйгээр олгосон мөнгөн урамшууллыг нөхөн төлүүлэх төлбөрийн акт тогтоох.

2. ЗДТГ-ын 2023 оны Б/27 дугаар тушаалыг үндэслэн тус байгууллагын нэг удаагийн тэтгэмж, урамшууллын батлагдсан төсвөөс улсын төсөвт байгууллагын 7 албан хаагчид нийт 920.0 мянган төгрөгийн тэтгэмж олгосон байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5 дахь “*Батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах*” гэсэн заалтыг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Улсын төсвийн байгууллагуудын албан хаагчдад олгосон мөнгөн урамшууллыг нөхөн төлүүлэх төлбөрийн акт тогтоох.

5.2 Албан шаардлага

1. Дараах байгууллагууд 13,807.4 мянган төгрөгийг зориулалт бусаар зарцуулж, гүйцэтгэлийг бодитоор тайлагнаагүй нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5 дахь “*Батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах*”, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.7 дахь “*Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн зөв гаргах үндэслэл болно*” гэсэн заалтууд болон Сангийн сайдын 2021 оны 61 дүгээр тушаалаар батлагдсан “Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журам”-ын 3.1.2 дахь заалтыг тус тус зөрчсөн байна.

ЗДТГ:

1. Засаг даргын нөөц хөрөнгийн батлагдсан төсвөөс тоног төхөөрөмж бэлтгэх, хөрөнгийн оруулалтын дараах 8,726.4 мянган төгрөг. Үүнд:

- Соёлын төвийн Лед дэлгэц худалдан авахад зориулж 4,476.4 мянган төгрөг,
- Ерөнхий боловсролын сургуулийн бохирын цооног соруулах 1,400.0 мянган төгрөг,
- Цэцэрлэгийн усан хангамжийн моторны үнэ 860.0 мянган төгрөг, цахилгааны ухаалаг тоолуур 1,045.0 мянган төгрөг,
- Эрүүн мэндийн төвийн машины сэлбэг 945.0 мянган төгрөг,

2.ИТХ:

- Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшууллын зардлаас үндэсний бичиг үсгийн өдрийг угтан зохион байгуулсан “Тунгаамал” тэмцээний оролцогчдод 160.0 мянган төгрөг, шатар сонирхогчдын сумын аварга шалгаруулах тэмцээний шагналд 200.0 мянган төгрөг, ИТХ-ын төлөөлөгч Д.Амаржаргалд 140.0 мянган төгрөгийн шагнал зэрэг нийт 500.0 мянган төгрөг.

➤ Бараа, үйлчилгээний бусад зардлаас ЗДНХ-өөс санхүүжих хуй салхи, галд өртсөн 2 малчин өрхөд 1,000.0 мянган төгрөгийн тусламж, байнгын асаргаатай 15 ахмадад нүүрсний үнэ 480.0 мянган төгрөг, 10

өрхөд эсгий дээвэр, хөнжил, цагаан хэрэгсэл худалдан авахад 3,101.0 мянган төгрөг зэрэг нийт 4,581.0 мянган төгрөг.

Шийдвэрлэсэн нь: Батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулж байх албан шаардлага хүргүүлэх.

2. Өмнөх очы аудитаар өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлээгүйгээс анхан шатны баримтын бүрдэлгүй дараах 33,841.0 мянган төгрөгийн ажил гүйлгээг гүйцэтгэж, бүртгэл тайланд тусгасан нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1 дэх “*Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн зөв гаргах үндэслэл болно*”, 13.7 дахь “*Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно*” гэсэн заалтыг зөрчсөн байна. Үүнд:

ЗДТГ:

- Ажил гүйцэтгүүлэх гэрээ, гүйцэтгэх ажил, зарцуулах материалын тооцоо, төсөв, ажил хүлээн авсан актгүйгээр “Архивын өрөөний засвар”-ын хөлсөнд бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамжийн батлагдсан төсвөөс иргэн Д.Болдбаатарт 2,289.0 мянган төгрөг, урсгал засварын төсвөөс материалын үнэнд Бурхант-Орд компанид 2,545.0 мянган төгрөг зэрэг нийт 4,834.0 мянган төгрөг,
- Зардлын тооцоо, төсөв, гүйцэтгэлийн тайлангүйгээр баяр наадмын зардалд 5,000.0 мянган төгрөг,
- Гүйцэтгэх ажлын төсөв, ажил хүлээн авсан актгүйгээр ЗДТГ-ын бохирын шугамыг засварлахаар Монжимтрейд компанид шилжүүлсэн 12,000.0 мянган төгрөг.

ЗДНХ:

- Зардлын төсөв, гүйцэтгэлийн тайлан, бараа материал бэлтгэн нийлүүлэгчийн зарлагын баримт, шагнал хүлээн авсан хүний гарын үсэггүйгээр “Ургацын баяр”-ын арга хэмжээнд 7,007.0 мянган төгрөг,
- Зардлын төсөв, гүйцэтгэлийн тайлан, бараа материал бэлтгэн нийлүүлсэн аж ахуйн нэгжийн зарлагын баримтгүйгээр аймгийн ЭМГ-тай хамтран зохион байгуулсан 2 удаагийн эрүүл мэндийн үзлэгийн зардалд 5,000.0 мянган төгрөг,

5.3 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1.Төсвийн төлөвлөлттэй холбоотой асуудал

Илрүүлэлт: Зайлшгүй гарах зардлыг төсөвт тусгаагүй буюу төсвийг иж бүрэн, үнэн зөв төлөвлөөгүйгээс **зардлын зориулалт болон арга хэмжээний ангилал** хооронд гүйлгэн зарцуулсан байна. Үүнд:

- Сумын ЗДТГ-ын төрийн өмчийн барилгын тогтмол зардлын /80111/ арга хэмжээний урсгал засварын зардлын батлагдсан төсвөөс байгууллагын үндсэн үйл ажиллагаатай /80101/ холбоотой гарах урсгал засварын / машин техник, барилга, худгийн засвар / зардалд 9,711.5 мянган төгрөгийг зарцуулсан байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1 дэх “Төсвийг төлөвлөх, батлах, хэрэгжүүлэх, тайлагнахад дараах зарчмыг баримтална”: 5.1.2: “Төсвийн иж бүрэн, үнэн зөв байдлыг хангасан байх”, Сангийн сайдын 2015 оны 7 дугаар тушаалаар баталсан “Зардлын зориулалт болон арга хэмжээний ангилал”-ын “80101: Үндсэн үйл ажиллагааны зардал”, “80111: Төрийн өмчийн барилгын тогтмол зардал” гэсэн заалтуудыг зөрчсөн байна.

Өгсөн зөвлөмж: Төсвийг зардлын зориулалт болон арга хэмжээгээр нь үнэн зөв, иж бүрэн төлөвлөж байх.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Байгууллагын нэр	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Залруулсан		Залруулаагүй		Тоо	Дүн
							Тоо	Дүн	Тоо	Дүн		
Тоног төхөөрөмжийг үндсэн хөрөнгөд орлого аваагүй	1	6,612.0	1	6,612.0			1	6,612.0				
Акталсан үлдэгдэл өртөгтэй хөрөнгийг бараа материал акталсан дансанд бүртгэсэн	1	904.5			1	904.5	1	904.5				
Дүн	2	7,516.5	1	6,612.0	1	904.5	2	7,516.5				

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Байгууллагын нэр	Нийт зөрчил		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн
ТТЗ	6	61,568.5	2	4,208.9	2	47,648.1	1	9,711.5	1	4		
Дүн	6	61,568.8	2	4,208.9	2	47,648.4	1	9,711.5	1	4		

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/мянган төгрөгөөр/

Байгууллагын нэр	Нийт зөрчил		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил								
ТТЗ нийт 52 мэдээллийг хугацаа хоцроож мэдээлсэн	1				1			
Дүн	1				1			
Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил								

Худалдан авах ажиллагааг хуулийн дагуу зохион байгуулаагүй	1	27,232.2					1	27,232.2
Дүн	1	27,232.2			1		1	27,232.2
Нийт дүн	2	27,232.2			1		1	27,232.2